



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 1/102

Хэрлэн сум

Тээврийн хэрэгслийн бүртгэлийн үйл ажиллагааг
шинэчлэн зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Автотээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.2, Сангийн сайд, Зам, тээвэр хөгжлийн сайдын 2017 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн хамтарсан 34/19 дүгээр тоот "Тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд сүүлийн 4-5 жилийн хугацаанд техникийн хяналтын үзлэгт хамрагдаагүй, шилжилт хөдөлгөөн хийгдээгүй, татвар төлөөгүй, Монгол улсын хилээр гараад орж ирээгүй олон жил болж байгаа тээврийн хэрэгслийг бүртгэлийн сангаас хасах, аймгийн хэмжээний тээврийн хэрэгслийн тоо бүртгэлийг үнэн бодит болгох ажлыг зохион байгуулан, хэрэгжүүлж ажиллахыг Автотээврийн төвийн дарга Б.Ганбат, Татварын хэлтсийн дарга А.Гантөмөр, сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

2. Бүртгэлд хамрагдаагүй мотоциклуудад дугаар олгох, зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор бүртгэлжүүлэх ажлыг орон нутагт зохион байгуулан, хэрэгжүүлж ажиллахыг Автотээврийн төвийн дарга Б.Ганбат, Цагдаагийн газрын дарга О.Ганбат, Татварын хэлтсийн дарга А.Гантөмөр, сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Засаг даргын орлогч /Г.Хэрлэнчулуун/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

01 505